



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/107

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.6.6 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 19 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Байгаль хамгаалах сарын аяны хүрээнд хүүхэд багачуудын байгаль хамгаалах мэдлэг хандлагыг дээшлүүлэх арга хэмжээний зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Зардалд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4.Байгаль хамгаалах сарын аян хүрээнд зохион байгуулсан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН



Засаг даргын 2024 оны 05 дугаар  
сарын 13-ны өдрийн А/109 дугаар  
захирамжийн хавсралт

БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САРЫН АЯНЫ ХҮРЭЭНД ХҮҮХЭД БАГАЧУУДЫН  
БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЭДЛЭГ ХАНДЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Хийгдэх ажил, арга хэмжээ, хэрэглэгдэх зүйлсийн нэр	Хэмжих нэгж тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
	1	2	3	4
1	Байгаль хамгаалах мэдлэг, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр хүүхэд багачуудад зориулсан бараа материал худалдан авч бэлтгэх	29	45,000	1,305,000
2	Байгаль хамгаалах мэдлэг, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр хүүхэд багачуудад зориулсан чихмэл болон гарын доорх материалаар хийх зүйлсийг бэлтгэх	8	20,000	160,000
3	Байгаль хамгаалах мэдлэг, хандлагыг дээшлүүлэх чиглэлээр хүүхэд багачуудад зориулсан танхимын засвар, тохижилтын ажил	5	307,000	1,535,000
4	Нийт дүн	42	372,000	3,000,000

---oOo---